



МОНГОЛ УЛС  
ӨМНӨГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГА

46083 Өмнөговь аймаг, Даланзадгад сум, 3 дугаар баг,  
Нутгийн удирдлагын ордон, 201 тоот  
Утас: (976)70533620, Факс: (976)70533604,  
И-мэйл: info@omnogovi.gov.mn, Вэб сайт: www.omnogovi.gov.mn

2020.01.03 № 1-30

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Журмын хэрэгжилтийг мөрдүүлж  
ажиллах тухай

2017 онд шинэчлэн батлагдсан Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймаг нийслэлийн Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд холбогдох журмуудыг батлан мөрдүүлэхээр заасан болно.

Дээрх хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны “Журам батлах тухай” 9/8 дугаар тогтоолын хавсралтаар “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”, 9/9 дүгээр тогтоолын хавсралтаар “Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх, энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэгж тариф”, аймгийн Засаг даргын 2019 оны “Журам батлах тухай” А/1354 дүгээр захирамжийн хавсралтаар “Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох журам”, А/1376 дугаар захирамжийн хавсралтаар “Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшуулал олгох журам”-ыг тус тус батлаад байна.

Ийм дээрх журмуудыг сумдад мөрдөж ажиллахад холбогдох мэргэжил арга зүйн сургалт, зөвлөгөөг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, хэрэгжилтийг хангуулж, хагас бүтэн жилээр аймгийн Засаг даргын Тамгын газарт тайлагнаж ажиллахыг чиглэл болгож байна.

Хавсралтаар батлагдсан журмуудыг хүргүүлэв.

ЗАСАГ ДАРГА



Н.НАРАНБААТАР



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2019 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 9/9

Даланзадгад

**Нэгж тариф батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 19 дүгээр зүйл 19.1.4, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/368 дугаар тушаал, Сангийн сайд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны 192,А/243 дугаар тушаалаар батлагдсан “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, булшлах зардлын нэгж тарифыг тооцох аргачлал”-ыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. “Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх, энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэгж тариф”-ыг хавсралтаар баталсугай.

2. Нэгж тариф батлагдсантай холбогдуулан сумын нутаг дэвсгэрт мөрдөгдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг холбогдох, хуулийн дагуу тогтоож, “Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх, энгийн хог хаягдлыг булшлах” зардлыг хог хаягдлын үйлчилгээний орлогоос санхүүжүүлэхийг аймаг, сумын Засаг дарга нарт даалгасугай.


3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг аймгийн Засаг дарга /Н.Наранбаатар/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Х.СУГИР

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн  
9/9 дүгээр тогтоолын хавсралт



**НИЙТИЙН ЭДЭЛБЭР ГАЗРЫН ХОГ ХАЯГДЛЫГ ЦЭВЭРЛЭХ, ЭНГИЙН ХОГ  
ХАЯГДЛЫГ БУЛШЛАХ ЗАРДЛЫН НЭГЖ ТАРИФ**

№	Үйл ажиллагааны төрөл	Хэмжих нэгж	Тариф/төгрөг
1	Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх	м <sup>2</sup> /төг	1.89
2	Энгийн хог хаягдлыг булшлах	тн/төг	2348

\_оОо\_



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2019 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 9/8

Даланзадгад

**Журам батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 19 дүгээр зүйл 19.1.4, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/443 дугаар тушаалаар батлагдсан “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага”-ыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмыг аймгийн хэмжээнд мөрдүүлэх ажлыг зохион байгуулан хэрэгжүүлэх, хог хаягдлын төвлөрсөн цэгийг тохижуулах, сэргээн ашиглах, дахин боловсруулах цэгийг байгуулах, хог хаягдлыг устгах, булшлах үйл ажиллагаанд шаардлагатай зардлыг аймаг, сумын төсөвт тусгаж ажиллахыг аймаг, сумын Засаг дарга нарт даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг аймгийн Засаг дарга /Н.Наранбаатар/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Х.СУГИР

**ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ ЦЭВЭРЛЭХ, АНГИЛАХ, ЦУГЛУУЛАХ,  
ТЭЭВЭРЛЭХ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ, СЭРГЭЭН АШИГЛАХ  
УСТГАХ, БУЛШЛАХ ЖУРАМ**

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. Энэхүү журмын зорилго нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж, удирдлага болгон мөрдүүлэх үйл ажиллагааг зохицуулна.

1.2. Энэхүү журмыг аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгж, байнга болон түр оршин суугч иргэн бүр дагаж мөрдөнө.

1.3. Журмыг сумдын Засаг дарга, Даланзадгад хотын Захирагчийн ажлын алба шууд хариуцан зохион байгуулж хэрэгжүүлнэ.

1.4. Журмаар зохицуулагдаагүй харилцааг “Хог хаягдлын тухай” хуулийг удирдлага болгон зохицуулна. Хуульд нэмэлт өөрчлөлт орсон тохиолдолд журамд зохих нэмэлт өөрчлөлтийг оруулна.

**ХОЁР. БАРИМТЛАХ ЗАРЧИМ, ЕРӨНХИЙ ШААРДЛАГА**

**2.1 Хог хаягдал үүсгэгч болон эрх бүхий этгээд үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтлана.**

2.1.1 Хог хаягдал үүсгэхгүй байх

2.1.2 Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь багасгах боломжийг бүрдүүлэх, эрэлхийлэх

2.1.3 Шинэ санаа, санаачлага гаргах дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх

2.1.4 Байгаль орчинд ээлтэй сэтгэлгээгээр хийж хэрэгжүүлэх

**2.2 Ерөнхий шаардлага**

2.2.1 Энгийн хог хаягдал цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, булшлах, устгах үйл ажиллагааг зохих шатны Засаг даргатай гэрээ байгуулж бүртгүүлсэн эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж байгууллага гүйцэтгэнэ.

2.2.2 Сумын Засаг даргатай гэрээ байгуулсан эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь үйл ажиллагаандаа холбогдох хууль, журам энэ чиглэлээр батлагдан гарсан Монгол Улсын стандартыг мөрдөн ажиллана.

2.2.3 Энгийн хог хаягдлыг дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэгч нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн дагуу байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэх.

2.2.4 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зохих мэдлэгтэй, зааварчилга авсан байна.

2.2.5 Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, дүрэмт хувцас, ялгах тэмдэгтэй байх.

2.2.6 Харилцааны соёлд суралцсан, байгаль хамгаалах, хог хаягдлын талаар нийгмийн хариуцлагаа ухамсарласан ажиллах хүчин байна.

2.2.7 Стандартын шаардлага хангасан зориулалтын тээврийн хэрэгсэл ашиглана.

2.2.8 Хог хаягдал үүсгэгч болон эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь зөвхөн энгийн хог хаягдал ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах ба аюултай хог хаягдал энэ тавигдах шаардлагад хамаарахгүй.

2.2.9 Эрх бүхий этгээд нь үйл ажиллагааны тайлан, мэдээг тоо, хэмжээ, нэр төрөл тус бүрээр гаргаж сар бүрийн 25-ны дотор тухайн шатны Засаг даргын Тамгын газарт хүргүүлж байна.

## **ГУРАВ. ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ ЦЭВЭРЛЭХ, АНГИЛАН ЯЛГАХ**

### **3.1 Энгийн хог хаягдлыг цэвэрлэх**

3.1.1 Сар бүрийн сүүлийн долоо хоногийн баасан гарагт нийтийн эзэмшлийн гудамж, хуваарьт талбайн болон аж ахуйн нэгж байгууллага бүр орчныхоо 50 метр талбайн хог хаягдал, цас мөсийг тогтмол цэвэрлэж байх.

3.1.2 Сар бүрийн сүүлийн долоо хоногийн бямба гарагт айл өрх бүр хашаа, байрны дотор, орц, гадна орчноо цэвэрлэж, хогоо ачуулж гудамж талбайн өнгө үзэмжийг сайжруулан засварлаж байх.

### **3.2 Энгийн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах**

3.2.1 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь үүсгэж буй энгийн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь болон үйл ажиллагааны явцад “дахин ашиглах, үнс, бусад” гэсэн төрлөөр ангилж эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хүлээлгэн өгнө.

3.2.2 Гэр хорооллын хог хаягдал ангилан хаях сав нь “дахин ашиглах, үнс, бусад хог”, албан байгууллага, аж ахуйн нэгж, нийтийн орон сууцны хог хаягдал ангилан хаях сав нь “дахин ашиглах, цаас, бусад хог” гэсэн хэсгээс бүрдэнэ.

**а/. Дахин ашиглах боломжтой хог хаягдалд дараах хог хаягдал хамаарна:**

- Цаас /хэт бохирдоогүй сонин, сэтгүүл, дэвтэр, бичгийн цаас, төрөл бүрийн боодлын цаас, картон цаас, сүү, жүүсний тетрапак савалгаа/
- Хуванцар /төрөл бүрийн ус, ундааны хуванцар сав, кетчуп, ургамлын тос, угаалга, цэвэрлэгээний нунтаг, шингэний хуванцар сав, авто машины тос, тослогооны шингэний хуванцар сав/
- 0.025 мм-ээс дээш зузаантай гялгар уут, баглаа боодол
- Хөнгөн цагаан, төмөр, металл, зэс, гууль тэдгээрээр хийсэн зүйл
- Шил /хүнсний болон бүх төрлийн шилэн сав, эдлэл/
- Лааз
- Мод, модон эдлэлийн хаягдал
- Хувцас, даавуун эдлэл, савхи, резин

**б/. Үнсэнд дараах хаягдал хамаарна:**

- Айл өрхийн ердийн зуух, пийшингийн
- Халаалтын болон нам даралтын зуухны
- Цахилгаан болон дулааны станцын зуухны

**в/. “Бусад хог хаягдал”** гэж аливаа хогоос дахин ашиглах боломжтой хог хаягдлыг зайлуулахад үлдсэн ахуйн хог хаягдлын хэсгийг хэлнэ. Бусад хог

хаягдалд аюултай хог хаягдал, барилгын хог хаягдал, цахилгаан барааны хаягдал, эмнэлгийн хог хаягдал орохгүй болно.

“Бусад хог хаягдал”-д дараах хог хаягдлыг оруулна. Үүнд:

- Нүүрс, модны үнс
- Түргэн муудах хоол, хүнсний хаягдал
- Ариун цэврийн хэрэглэлийн хаягдал
- Дахин ашиглагдах

### **3.3 Энгийн хог хаягдлыг ангилан ялгах хогийн сав дараах шаардлагыг хангасан байна.**

а. Ангилан ялгах хог хаягдлын төрлөөр хогийн савыг өнгөөр ялгасан, эсвэл ангилах, ялгах зориулалтын тэмдэг, тэмдэглэгээ бүхий байж болно.

б. Айл гэрт 5-10, хашаанд 80-120, байгууллагын дотор 10-40, гадна 80-150 литрийн багтаамжтай байна.

в. Цоорч гэмтээгүй, салхиар тархахгүй, шингэн нэвчихгүй, угааж цэвэрлэхэд хялбар

г. Тагтай, хуванцар, металл материалаар хийгдсэн

## **ДӨРӨВ. ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ**

### **4.1 Энгийн хог хаягдлыг цуглуулах**

4.1.1 Хог хаягдал цуглуулах зориулалт бүхий сав нь тээвэрлэх зориулалт бүхий уяа, дэгээтэй, хог хаягдал ачих тээврийн хэрэгсэлд зориулагдсан байна.

4.1.2 Хог хаягдал цуглуулах зориулалт бүхий сав, төхөөрөмжийн хог хаягдал хадгалах, цуглуулах багтаамж нь 3 хоногоос ихгүй байна.

4.1.3 Хог хаягдлыг цуглуулахдаа ангилан ялгасан хог хаягдал тус бүрээр цуглуулна.

4.1.4 Дахин ашиглах хог хаягдлыг цуглуулахдаа цэг байгуулах болон явуулын машинт үйлчилгээ ажиллуулж цуглуулна. /үйлчилгээний газрууд, нийтийн орон сууц, хогийн цэг/

4.1.5 Дахин ашиглах хог хаягдлыг цуглуулах цэгийг орон сууцны хороолол, нийтийн эзэмшлийн талбай, явган хүн, авто машины хөдөлгөөнд саад учруулхааргүй газарт байгуулна.

4.1.6 Салхин доод талд, гэр байшин, хүнс боловсруулах, хадгалах газар, хүүхдийн тоглоомын талбайгаас 20-30 метрт байрлуулсан байна.

4.1.7 Хогийн сав байршуулах талбайн хөрсийг тэгшлэн нягтаршуулсан, цементэлсэн зориулалтын хавтан дэвсгэр дэвссэн байна.

4.1.8 Тээврийн хэрэгсэл чөлөөтэй нэвтрэх зай талбайтай байна.

### **4.2 Энгийн хог хаягдлыг тээвэрлэх**

4.2.1 Энгийн хог хаягдлыг тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь зориулалтын битүүмжлэлтэй, технологийн болон аюулгүй ажиллагааны шаардлага хангасан, задгай тэвштэй тээврийн хэрэгслээр тээвэрлэх бол хог хаягдал хийсэхгүй, асгахгүй байх нөхцөлийг хангасан байна.

4.2.2 Тээвэрлэх хог хаягдлын төрөл, ангиллыг заасан тэмдэг тэмдэглэгээтэй байх.

4.2.3 Хотын өнгө үзэмжид нийцсэн цэвэрхэн, зориулалтын байх.

4.2.4 Дуудлагаар хог хаягдал тээвэрлэж болох ба энэ талаар журмын 2.2.1 дэх заалтад заасан гэрээнд тодорхой тусгана.

4.2.5 Батлагдсан маршрут, хуваарийн дагуу тээвэрлэнэ.

4.2.6 Хог хаягдлыг тээвэрлэх график, маршрутыг жил, улирал, сараар гаргаж хог хаягдал тээвэрлэх гэрээ байгуулснаас хойш 5 хоногт багтаан сумын Засаг даргаар батлуулна.

## **ТАВ. ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ, СЭРГЭЭН АШИГЛАХ**

### **5.1 Энгийн хог хаягдлыг дахин боловсруулах**

5.1.1 Дахин боловсруулах үйл ажиллагаа эрхлэгч нь түүхий эд болох хог хаягдлыг өөрөө болон эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж байгууллагаар дамжуулан цуглуулж болно.

5.1.2 Хог хаягдлыг дахин боловсруулах арга, технологи нь байгаль орчинд ээлтэй, орчин үеийн, хүлээн зөвшөөрөгдсөн дэвшилтэт техник, технологи байна.

5.1.3 Дахин боловсруулах үйлдвэрээс гарсан шинэ бүтээгдэхүүн нь байгаль орчинд сөрөг нөлөөгүй, хүн, мал, ургамал, амьтанд аюулгүй, хүний хэрэгцээ, шаардлагыг хангасан байна.

### **5.2 Энгийн хог хаягдлыг сэргээн ашиглах**

5.2.1 Хог хаягдлыг дараах байдлаар ашигласныг сэргээн ашиглах гэнэ.

а. Хог хаягдлыг байгаль орчинд ээлтэй технологиор олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, зориулалтын байгууламж, тоног төхөөрөмжид зөвшөөрсөн газарт шатааж, эрчим хүч /цахилгаан, дулаан, халуун ус/ үйлдвэрлэх.

б. Байгаль орчинд ээлтэй нөхцөлөөр, зөвшөөрсөн арга технологиор хог хаягдлыг нэрэх, угаах, халдваргүйжүүлэх, цэвэрлэх, сэргээх аргаар боловсруулж, эргүүлэн ашиглах чанарын шаардлага хангасан, эдийн засгийн хувьд ашигтай болгож хог хаягдлыг анхны хэлбэрт оруулах.

в. Хог хаягдал сэргээн ашиглах технологи нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, ашигласан бүтээгдэхүүн нь хүн, мал, амьтан, ургамалд хор хөнөөлгүй байна.

г. Төвлөрсөн хогийн цэгт хог хаягдлыг шатааж, эрчим хүч үйлдвэрлэх, үйлдвэр барьж болох ба хог хаягдлыг тээвэрлэж, төвлөрсөн хогийн цэгт хүргэх боломжгүй алслагдсан газар, суурин газарт өндөр даралт болон битүүмжлэл бүхий хог хаягдал шатаах зориулалтын, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, байгаль орчны холбогдох байгууллага хүлээн зөвшөөрсөн жижиг оврын хог хаягдал шатаах байгууламж ашиглан дулаан, халуун ус үйлдвэрлэж сэргээн ашиглаж болно.

## **ЗУРГАА. ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ УСТГАХ, БУЛШЛАХ**

6.1 Эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь сэргээн ашиглах, дахин боловсруулах боломжгүй хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөгүй, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга технологиор устгаж булшилна.

### **6.2 Энгийн хог хаягдлыг устгах**

6.2.1 Хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх зорилгоор энгийн хог хаягдлыг устгахад дараах төрлийн үйл ажиллагаа хамаарна.

а. Химийн аргаар зарим төрлийн хог хаягдлыг урвалд оруулж, боловсруулж устгах.

б. Биологийн аргаар байгальд ээлтэй нөхцөлөөр боловсруулж устгах.



- в. Зориулалтын байгууламжид хог хаягдлыг шатаах.
- г. Хог хаягдлыг халдваргүйжүүлж, байгальд хоргүй болгож устгах.

### **6.3 Энгийн хог хаягдлыг булшлах**

6.3.1 Хог хаягдлын төвлөрсөн цэгт эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хог хаягдлыг зориулалтын тоног төхөөрөмжөөр ландфилл аргаар газарт булшлах.

6.3.2 Хог хаягдлыг булшлах ажиллагаа нь дэлхийн эрүүл мэндийн болон байгаль орчны холбогдох байгууллагуудаас гаргасан зөвлөмжийн дагуу байгаль орчинд хоргүй нөхцөлөөр, ландфилл аргаар хийгдэнэ.

## **ДОЛОО. ХҮЛЭЭХ ҮҮРЭГ**

### **7.1 Аймгийн Засаг даргын хүлээх үүрэг:**

7.1.1 Журмын хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцох.

7.1.2 Журмыг хэрэгжүүлэхэд сумдын Засаг дарга болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг бодлогоор дэмжиж ажиллах

### **7.2 Сумын Засаг даргын хүлээх үүрэг:**

7.2.1 Журмын хэрэгжилтийг зохион байгуулж, иргэн аж ахуйн нэгж байгууллагад сурталчлах, сургалт зохион байгуулах.

7.2.2 Хог хаягдлын төвлөрсөн цэгийг тохижуулах, сэргээн ашиглах, дахин боловсруулах цэгийг байгуулах, хог хаягдлыг устгах булшлахад шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусгах.

7.2.3 Хог хаягдлыг цуглуулах тээвэрлэх график, маршрутыг батлах, хяналт тавих.

7.2.4 Анхан шатанд ахуйн хог хаягдлыг ангилан ялгасан, бусдад үлгэр дуурайл болсон айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, олон нийтэд сурталчлах.

7.2.5 Хог хаягдлыг бууруулах, төвлөрсөн цэгийг тохижуулах, устгах, булшлах үйл ажиллагаанд тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын техник хэрэгслийг ашиглаж болно.

7.2.6 Эрүүл мэнд, барилга, зам тээвэр, батлан хамгаалахын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагуудыг хог хаягдлаа тухайн чиглэлийн төрийн захиргааны төв байгууллагаас батлан гаргасан журмын дагуу тээвэрлэх, устгах, булшлахыг шаардах, хяналт тавих.

7.2.7 Аюултай хог хаягдлыг түр байршуулах газрыг байгаль орчин, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн байгууллагуудын үнэлгээ, дүгнэлтийг үндэслэн тогтоож, түр хадгалах байр, түүнийг тээвэрлэх, зам, маршрут гарган батална.

7.2.8 Хог хаягдлын тайлан, мэдээг холбогдох иргэн аж ахуйн нэгж, байгууллагаас хугацаанд нь авч 6, 12 дугаар сарын 10-ны дотор Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүргүүлэх

### **7.3 Багийн Засаг даргын хүлээх үүрэг:**

7.3.1 Энгийн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилах үйл ажиллагаанд хяналт тавих, иргэд аж ахуйн нэгж, байгууллагад хог хаягдлыг бууруулах, ангилах, сэргээн ашиглах, дахин боловсруулах мэдээлэл, сургалтыг тогтмол зохион байгуулах.

7.3.2 Баг хороодод сайн дурын идэвхтэн ажиллуулах, хяналт тавих, дэмжин ажиллах

7.3.3 Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн аж ахуйн нэгж байгууллагын тээвэрлэлтийн график, хугацаа давтамжид хяналт тавьж хамтран ажиллах.

7.3.4 Нийтийг хамарсан цэвэрлэгээ зохион байгуулахад гэр хороолол, СӨХ-тэй хамтран орон сууцны айл өрхийн иргэдийг татан оролцуулах.

7.3.5 Байгалийн давтагдашгүй хүчин зүйлийн нөлөөгөөр үхсэн малын сэг зэмийн устгаж хяналт тавьж ажиллах.

7.3.6 Бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэн тусгай ажилтан томилон ажиллах хог хаягдлын хураамжаас санхүүжүүлэх.

#### **7.4 Аж ахуйн нэгж, байгууллагын хүлээх үүрэг:**

7.4.1 Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилж, цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж байгууллагад батлагдсан хуваарийн дагуу хүлээлгэн өгөх.

7.4.2 Барилга барих, буулгах, засварлах үйл ажиллагаанаас гаргах хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах булшлах эрх бүхий иргэн аж ахуйн нэгж байгууллагад шилжүүлж үйлчилгээний хөлсийг хариуцах, эдгээр үйл ажиллагаатай холбоотой гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, байгууллагын дотоод болон гадна орчны цэвэрлэгээг хариуцах үүрэг бүхий нэгж эсхүл ажилтантай байх

7.4.3 Эмнэлгийн болон барилгын хог хаягдлыг Барилга болон Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу ангилах, цуглуулах, тээвэрлэх, устгах

7.4.4 Стандартын шаардлага хангасан ангилан ялгах хогийн савтай байх, шаардлагатай цэгт ангилан ялгах хогийн сав байршуулах.

7.4.5 Мэдээ, тайлан гаргах, хог хаягдлын тооллого судалгаатай байх, төсөв хөрөнгө төлөвлөх, нийтийг хамарсан цэвэрлэгээнд оролцох.

#### **7.5 Орон сууцны хорооллын айл өрхийн хүлээх үүрэг:**

7.5.1 Энгийн хог хаягдлаа энэхүү журмын 3.2.2 дахь заалтад заасны дагуу ангилж, дахин боловсруулах хог хаягдлаа эрх бүхий иргэн аж ахуйн нэгж байгууллагад хүлээлгэн өгөх.

7.5.2 Энгийн болон дахин боловсруулах хог хаягдлыг орц болон зориулалтын бус цэгт хаясан, айл өрхийг үнэн зөв баримттай мэдээлэх.

7.5.3 Нийтийн цэвэрлэгээнд идэвхтэй оролцож нийтийн эзэмшлийн зам талбай болон орц, байрны ойр орчмыг цэвэрлэж байх.

#### **7.6 Гэр хорооллын айл өрхийн хүлээх үүрэг:**

7.6.1 Энгийн хог хаягдлаа энэхүү журмын 3.2.2 дахь заалтад заасны дагуу ангилж, зориулалтын тагтай саванд хадгалах, батлагдсан хуваарийн дагуу хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүлээлгэн өгч, хамтран ажиллах.

7.6.2 Нийтийн цэвэрлэгээнд идэвхтэй оролцож, хашааны дотор болон гадна хэсгийн ойр орчмын гудамж талбайг цэвэрлэх.

#### **7.7 СӨХ-ийн хүлээх үүрэг:**

7.7.1 Харьяалж буй орон сууцныхаа оршин суугчдад энгийн хог хаягдлыг ангилан ялгаж, хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх өдөр, хуваарийн талаар мэдээллээр хангах.

7.7.2 Багийн Засаг дарга болон сумын ЗДТГ-ын холбогдох мэргэжилтэнтэй хамтран оршин суугчдад сургалт, сурталчилгаа явуулах, нийтийн цэвэрлэгээнд татан оролцуулах.

7.7.3 Оршин суугчдын эрүүл, аюулгүй, таатай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж орц, байрны орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийг хийх хугацааг тодорхой гаргаж тогтмолжуулах.

**7.8 Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүлээх үүрэг:**

7.8.1 Энэхүү журмын 2.2-т заасан ерөнхий шаардлагыг ханган ажиллах.

7.8.2 Иргэдийн санал, гомдлыг шийдвэрлэж, шуурхай байдлыг ханган ажиллах.

7.8.3 Зориулалтын бус газарт хог хаясан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, зөрчил гомдлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд үнэн зөв мэдээлэх, зөрчлийг арилгахад хамтран ажиллах.

## **НАЙМ. ХЯНАЛТ ТАВИХ, ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ:**

**8.1 Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах үйл ажиллагаанд дараах этгээд хяналт тавина.**

8.1.1. Сум, багийн Засаг дарга

8.1.2. Эрх бүхий Улсын байцаагч, албан тушаалтан

**8.2 Хариуцлага хүлээлгэх:**

8.2.1 Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Улсын байцаагч, Цагдаа, сум, багийн Засаг дарга нь Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

## **ЕС. УРАМШУУЛАЛ**

9.1 Хог хаягдлыг анхан шатанд ангилан, ялгаж хэвшсэн, хог хаягдлыг дахин ашиглах шинэ санал санаачилгыг гаргасан, мөн хоёрдогч түүхий эдийг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулахад бусдад үлгэр дуурайл болсон айл өрх, иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулж, олон нийтэд сурталчилан, бүх талаар дэмжиж ажиллана.

9.2 Дээрх дэмжлэг, урамшууллын арга хэмжээг тухайн иргэн аж ахуйн нэгжийн хүсэлт, багийн Засаг даргын тодорхойлолтыг үндэслэн сумын Засаг дарга зохион байгуулна.

9.3 Урамшууллын механизмыг хэрэгжүүлэхдээ Монгол улсын Засгийн газрын 2015 оны 263 дугаар тогтоол /Хог хаягдлыг бууруулах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах үйл ажиллагаа эрхэлсэн болон хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг сурталчилж, урамшуулал олгох журам/-ыг мөрдлөг болгоно.



МОНГОЛ УЛС  
ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 18 өдөр

Дугаар A/1354

Даланзадгад

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "а" дахь заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.2, 9.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох журмыг хавсралтаар баталсугай.

2.Журмын хэрэгжилт хангах ажлыг зохион байгуулж, тайлагнаж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар /Б.Пүрэвтулга/, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох байгууллагад тайлагнаж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Ж.Сүх-Эрдэнэ/-т даалгасугай.

Хавсралт 3 хуудастай


ЗАСАГ ДАРГА



Н.НАРАНБААТАР

461192229

Аймгийн Засаг даргын 2019 оны 12 сарын  
18-ны өдрийн А/1354 дүгээр захирамжийн  
хавсралт



**ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫН ТӨВЛӨРСӨН ЦЭГИЙН БОЛОН  
ХОГ ХАЯГДЛЫГ СЭРГЭЭН АШИГЛАХ, УСТГАХ, БУЛШЛАХ  
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журам нь хогийн цэгийн үйл ажиллагаа болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Хог хаягдал булшлах, устгах зориулалтын байгууламж, төвлөрсөн цэгийн төрөл, тэдгээрт тавигдах шаардлага болон хог хаягдлыг сэргээн ашиглах, булшлах, устгах ажил эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд энэхүү журмыг удирдлага болгоно.

1.3. Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгт хог хаягдлыг булшлах, устгах үйл ажиллагааг Хог хаягдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасан аж ахуйн нэгж, байгууллагатай сумын Засаг дарга гэрээ байгуулан гүйцэтгүүлж болно.

1.4. Энэхүү журамд орсон нэр томъёог Хог хаягдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар ойлгоно.

**Хоёр. Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, тэдгээрт тавигдах шаардлага**

2.1. Сумдад энгийн хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, хогийн цэгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг аймгийн Засаг даргын захирамжаар олгоно.

2.2. Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн үйл ажиллагааг сумдын Засаг даргын Тамгын газар хариуцаж ажиллана.

2.3. Төвлөрсөн суурин газраас бусад газарт удаан хугацаагаар үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудад хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах зөвшөөрлийг аймгийн Засаг даргын захирамжаар олгож, сумын Засаг дарга гэрээ байгуулан ажиллана.

2.3.1. Удаан буюу 5-аас дээш жил үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллагад хог хаягдлын төвлөрсөн цэгийн зөвшөөрөл олгож, жил бүр гэрээ байгуулан ажиллана.

2.4. Төвлөрсөн суурин газраас бусад газарт түр хугацаагаар үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудад хог хаягдлын түр цэгийн зөвшөөрлийг сумын Засаг даргын захирамжаар олгож, гэрээ байгуулан ажиллана.

2.4.1. Түр буюу 5 хүртэлх жил үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллагад хог хаягдлын түр цэгийн зөвшөөрөл олгож, жил бүр гэрээ байгуулан ажиллана.

2.5. Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, төвлөрсөн цэгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авахад дараах материалыг бүрдүүлж аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ. Үүнд:

2.

2.5.1. Аж ахуйн нэгжийн албан хүсэлт

2.5.2. Сумын энгийн хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах газрын кадастрын зураг

2.5.3. Хогийн цэгийн үйл ажиллагааны танилцуулга /хогийн цэгийн байршил, хамрах талбай, жилд төвлөрүүлэх хогийн хэмжээ гэх мэт.../

2.5.4. Хогийн цэгийн орчны байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт

2.6. Хог хаягдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасны дагуу бүртгүүлж, дугаар авсан аж ахуйн нэгж, байгууллагад хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг аймгийн Засаг даргын захирамжаар олгож, сумын Засаг дарга гэрээ байгуулан ажиллана.

2.7. Энгийн хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авахад дараах материалыг бүрдүүлж аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ. Үүнд:

2.7.1. Аж ахуйн нэгжийн албан хүсэлт

2.7.2. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлсэн маягтын хуулбар

2.7.3. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар

2.7.4. Сумын Засаг даргын дэмжсэн албан бичиг

2.7.5. Хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагааны төсөл

2.8. Хог хаягдал булшлах, устгах зориулалтын байгууламж, төвлөрсөн цэгийн байршил нь дараах шалгуурыг хангасан байна.

2.8.1. Хүн амын суурьшлын хэтийн бүсээс гадна орших

2.8.2. Тухайн суурин газрын уур амьсгалын төлөв байдалд сөрөг нөлөөгүй буюу салхины чигийн доод хэсэгт

2.8.3. Хүрээлэн буй орчин, хөрсний үржил шим, геологи, газар зүйн тогтоц нь судлагдсан байх

2.8.4. Зам, шугам сүлжээний зориулалтаар ашиглагдахгүй газар байх

2.8.5. Газрын гадаргын болон гүний усны нөөц бүхий газраас ангид байх

2.8.6. Түүх, соёлын дурсгалт болон байгалийн өвөрмөц тогтоц бүхий газартай давхцаагүй байх


2.8.7. Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөгөөр аж ахуйн эдэлбэрийн зориулалтаар ашиглахаар хуваарилагдсан газраас ангид байх

2.8.8. Хаягдлын эх үүсвэрт аль болох ойр байх


2.9. Төвлөрсөн цэг, байгууламж байгуулахаар зөвшөөрөл олгосон газарт үйл ажиллагаа эхлэхээс өмнө байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэнэ.

2.10. Энгийн хог хаягдал сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах үйл ажиллагаанд болон төвлөрсөн цэг, байгууламжид тавих шаардлагад Хог хаягдлын тухай хуулийн 16, 17 дугаар зүйлийг, төвлөрсөн цэгт хог хаягдлыг булшлах, ландфиллыг хаахад Хог хаягдлын тухай хуулийн 18, 19 дүгээр зүйлийг баримтална.

2.11. Төвлөрсөн цэг, байгууламжийн ажлын дэглэм, цагийн хуваарийг сумын Засаг даргаар баталгаажуулан мөрдөнө.



2.12.Төвлөрсөн цэг, байгууламжийн эргэн тойронд 500 м-ийн зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүс тогтоож, уг бүсэд хүн ам оршин суух, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх, хог хаягдал булшлах, устгах, сэргээн ашиглах зориулалтаас бусад барилга, байгууламж барих зэрэг аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно.



**Гурав. Хог хаягдал булшлах, устгах, сэргээн ашиглах үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад тавигдах шаардлага**

3.1. Хог хаягдал булшлах, устгах үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага нь хог хаягдлыг төвлөрсөн цэгт хүлээн авч хүрээлэн буй орчинд халгүй аргаар булшлах, устгах үйл ажиллагаа явуулна.

3.2.Хог хаягдал булшлах, устгах үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага нь төвлөрсөн цэг, байгууламжийн үйл ажиллагааг эрхлэн зохицуулах үүрэг бүхий орон тооны зохицуулагчтай байна.

3.3.Төвлөрсөн цэг, байгууламжийн ажиллах цагийн хуваарь, уг цэгт хүлээн авахгүй хог хаягдлын жагсаалт, шаардлагатай утасны дугаар, хог хаягдал хүлээн авахтай холбогдолтой мэдээллүүдийг оруулсан дүрэмтэй байна.

3.4.Төвлөрсөн цэг, байгууламжид ажиллах ажилчдыг сургаж, дадлагажуулсан байх бөгөөд ажилчид тус бүрийн ажил үүргийн хуваарь, чиглэлийг заасан ажлын байрны тодорхойлолттой байна.

3.5.Төвлөрсөн цэг, байгууламжид шаардлагатай техник, багаж, хэрэгсэлтэй байна.

3.6.Хог хаягдал булшлах, зориулалтын байгууламж, төвлөрсөн цэгт ажиллагсдын хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн болон аюулгүй ажиллагааны нөхцөлийг хангах асуудлыг бүрэн хариуцна.

3.7.Хог хаягдлыг сэргээн ашиглах аж ахуйн нэгж, байгууллага нь байгальд халгүй аргаар үйл ажиллагаа явуулна.

**Дөрөв. Хяналт, шинжилгээ**

4.1.Хог хаягдал булшлах, устгах, сэргээн ашиглах зориулалтын байгууламж, төвлөрсөн цэгийн үйл ажиллагаанд тус үйл ажиллагааг эрхлэгч дотоод хяналтыг байнга хийнэ.

4.2. Хог хаягдал булшлах, устгах, сэргээн ашиглах зориулалтын байгууламж, төвлөрсөн цэгийн үйл ажиллагаанд хяналт тавих үйл ажиллагааг Хог хаягдлын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу хэрэгжүүлнэ.

4.3. Хог хаягдал булшлах, устгах зориулалтын байгууламж, төвлөрсөн цэгийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчны шинжилгээг тусгайлан тогтсон газраас зургаан сард нэг удаа, бактерийн шинжилгээг гурван сард нэг удаа хийлгэнэ.



МОНГОЛ УЛС  
ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 20 өдөр

Дугаар A/1376

Даланзадгад

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "а" дахь заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.12 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшуулал олгох журмыг хавсралтаар баталсугай.

2.Журмын хэрэгжилт хангуулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар /Б.Пүрэвтулга/, үйл ажиллагаанд шаардагдах зардлыг жил бүрийн сумын төсөвт батлуулж, тайлагнаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох байгууллагад тайлагнаж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Ж.Сүх-Эрдэнэ/-т даалгасугай.

Хавсралт 3 хуудастай

ЗАСАГ ДАРГА




Н.НАРАНБААТАР

461192279



Аймгийн Засаг даргын 2019 оны 12 сарын  
20-ны өдрийн А/1376 дугаар захирамжийн  
хавсралт



## ХОГ ХАЯГДЛЫН ОЛОН НИЙТИЙН БАЙЦААГЧ АЖИЛЛУУЛАХ, МӨНГӨН УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл.

1.1. Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, зохион байгуулах, хог хаягдлын хуулийг сурталчлах хог хаягдлын олон нийтийн байцаагч /цаашид "олон нийтийн байцаагч" гэх/ ажиллуулах, урамшуулал олгох, үйл ажиллагаанд хяналт тавихтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Журмын зорилго нь сумын иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор сумын нутаг дэвсгэрт хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулж хог хаягдлын чиглэлээр гаргасан хууль тогтоомжийг сурталчлах, биелэлтийг хангуулах, хяналт тавих, зөрчил дутагдлыг арилгуулахад оршино.

1.3. Олон нийтийн байцаагч нь үйл ажиллагаандаа Хог хаягдлын тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх бүхий байгууллагын болон аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, бүх шатны Засаг даргын шийдвэр болон энэхүү журмыг дагаж мөрдөнө.

### Хоёр. Олон нийтийн байцаагчид тавигдах шаардлага

2.1. Монгол Улсын иргэн, 18-аас дээш хөдөлмөрийн насны, иргэний эрх зүйн чадамжтай бүрэн дундаас дээш боловсролтой

2.2. Иргэдийн итгэл хүлээсэн, харилцааны соёлтой, хууль сурталчлах зохион байгуулах, багаар ажиллах, шаардлага тавих чадвартай байх

2.3. Сумын байнгын оршин суугч байх

2.4. Гэмт хэрэгт холбогдож байгаагүй

### Гурав. Олон нийтийн байцаагчийг томилох, чөлөөлөх, ажиллах нөхцөлөөр хангах

3.1. Уг журмын 2 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан олон нийтийн байцаагчийг сумын Засаг дарга томилно.

3.2. Томилоход доорх бичиг баримтыг бүрдүүлж, сумын Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ. Үүнд:

3.2.1 Анкет

3.2.2 Олон нийтийн байцаагчаар ажиллах тухай хүсэлт

3.2.3 Иргэний үнэмлэхийн хуулбар

3.2.4 Боловсролын үнэмлэх, дипломын хуулбар

3.2.5 Байгаль орчны хяналтын улсын байцаагчийн санал

3.2.6 Гэмт хэрэгт холбогдож байгаагүй тухай тодорхойлолт

3.2.7 3\*4 хэмжээтэй цээж зураг 2 ширхэг

2.

3.3.Сумын Засаг даргын Тамгын газарт ирүүлсэн материалыг үндэслэн сумын Засаг даргын захирамжаар байцаагчийг томилж, чөлөөлнө.

3.4.Сумын Засаг даргын захирамжийг үндэслэн Тамгын газрын дарга Олон нийтийн байцаагчтай жил бүр гэрээ байгуулах ба гэрээнд хариуцах ажил, талуудын харилцан хүлээх үүрэг, урамшуулал, гэрээ цуцлах үндэслэлийг заана.

3.5.Олон нийтийн байцаагч нь ажлын төлөвлөгөөг сумын Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулан хэрэгжүүлж ажиллана.

3.6.Олон нийтийн байцаагчийн гэрээг ажлын үр дүн, зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулахаар авсан арга хэмжээг харгалзан жил бүр сунгана.

3.7.Олон нийтийн байцаагч нь сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны бус, гэрээт ажилтан байна.

3.8.Сумын Засаг даргын тамгын газар хог хаягдлын олон нийтийн байцаагчийг ажиллах өрөө тасалгаа, техник хэрэгсэл, нормын хувцас, хэрэгслээр хангана.

3.9.Олон нийтийн байцаагч нь сумын Засаг даргын Тамгын газарт харьяалагдах ба сумын Засаг даргаас олгосон албаны үнэмлэхтэй байна.

3.10.Хог хаягдлын олон нийтийн байцаагчийг дараах тохиолдолд гэрээг цуцалж, чөлөөлнө.

3.10.1.Гэрээнд заасан эрх, үүргээ хэрэгжүүлээгүй, албан тушаалаар хүлээсэн эрхээ хэтрүүлэн ашигласан нь нотлох баримтаар тогтоогдсон бол

3.10.2.Өөр ажил, албан тушаалд томилогдох болсон

3.10.3. Гэмт хэрэг үйлдсэн нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон бол

3.10.4 Эрүүл мэндийн болон бусад шалтгаанаар өөрөө хүсэлтээ гаргасан бол

**Дөрөв. Хог хаягдлын олон нийтийн байцаагч дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллана**

4.1.Олон нийтийн байцаагч нь Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Орчны эрүүл ахуйн тухай хууль, Агаарын тухай хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан эрх бүхий байгууллага аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, бүх шатны Засаг даргын шийдвэрийг сурталчлах, хэрэгжүүлэхээс гадна дараах чиглэлийн үйл ажиллагаанд хяналт тавина.

4.2.Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн тохижилт, цэвэрлэгээ, нийтийн эзэмшлийн тавилга, эд хөрөнгийн арчлалт, хамгаалалт, үерийн хамгаалалтын далан суваг, барилга байгууламжийн засвар, цэвэрлэгээ үйлчилгээнд хяналт тавих, орон сууцны болон гэр хорооллын гудамж, зам талбайд ил задгай хог хаягдал үүсэхээс урьдчилан сэргийлэх, гарсан зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллана.

4.3. Хариуцсан нутаг дэвсгэрийн байнга болон түр оршин суугч айл өрх, аж ахуй нэгж байгууллагатай хог хаягдлын гэрээ байгуулж, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого төвлөрүүлэх болон гэрээний биелэлтэд хяналт тавина.

4.4.Хот, нийтийн эд аж ахуй, байгаль экологи, хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлөх үйлдлийг таслан зогсоож, холбогдох хууль тогтоомжоор олгогдсон

3.

эрхийн хүрээнд илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээ авч эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэнэ.

4.5.Хариуцсан нутаг дэвсгэрийн аж ахуй нэгж, байгууллагын хариуцах ойр орчны 50м хүртэлх нийтийн эдэлбэр газар, авто машины болон явган хүний замын хог хаягдал, цас, мөсийг цэвэрлүүлэх, тохижилтыг хийлгэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих, аж ахуй нэгж байгууллагын идэвх санаачлагыг нэмэгдүүлэх.

4.6.Бүх нийтийг хамарсан ажилд хариуцсан нутаг дэвсгэрийн иргэд, байгууллага, аж ахуй нэгжийг бүрэн хамруулах, зар түгээх, сурталчлах.

4.7.Хог хаягдлын талаарх олон нийтийн боловсролыг дээшлүүлэх ажилд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, багийн Засаг даргатай хамтран ажиллана

4.8.Хог хаягдлыг бууруулах, эдийн засгийн эргэлтэд оруулах санал санаачилга гаргах зохион байгуулах үүрэг бүхий орон тооны бус иргэдийн бүлэг байгуулж ажиллуулахад багийн Засаг даргатай хамтран ажиллана.

4.9.Хариуцсан багийн нутаг дэвсгэрийг хог хаягдалгүй, орчны бохирдолгүй байлгахад чиглэсэн шинэлэг санал санаачлага гаргаж, хэрэгжүүлэх.

4.10.Тухайн нутаг дэвсгэрт тогтоосон агаарын чанарыг сайжруулах хязгаарлалтын бүсийн журам, дүрмийг хэрэгжүүлэхэд хяналт тавих.

4.11.Удаа дараа зөрчил гаргасан, тавьсан шаардлагыг биелүүлээгүй иргэн, аж ахуй нэгж байгууллагад хууль тогтоомжид заасан хариуцлагыг тооцуулах, цуцлуулах саналыг холбогдох эрх бүхий этгээдэд тавьж, шийдвэрлүүлэх.

#### **Тав. Зөрчил хянах**

5.1.Хог хаягдлын олон нийтийн байцаагч нь хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэхдээ илэрсэн зөрчлийн талаар эрх бүхий улсын байцаагчид нэн даруй танилцуулж холбогдох арга хэмжээг авахуулна.

#### **Зургаа. Тайлан хүргүүлэх**

6.1.Олон нийтийн байцаагч нь ажлын тайланг сар, хагас жил, бүтэн жилээр гаргаж сумын Засаг даргын Тамгын газарт өгнө.

6.2.Илрүүлсэн зөрчил, дутагдлын дагуу авсан арга хэмжээний мэдээг сумын Засаг даргад сар бүрийн 05-ны өдрийн дотор хүргүүлнэ.

#### **Долоо. Мөнгөн урамшуулал олгох**

7.1.Хог хаягдлын олон нийтийн байцаагчийн урамшууллыг Төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн шатлалтай жишиж тооцож олгоно.

7.2.Сумын Засаг дарга олон нийтийн байцаагчийн мөнгөн урамшууллын зардлыг жил бүр орон нутгийн төсөвт тусгаж, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж хэрэгжүүлнэ.

7.3.Олон нийтийн байцаагчийн ажлын үр дүнгээс хамааруулан жилд 1 удаа мөнгөн шагнал олгож болно.